# “ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2026/004/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/246

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-ҮҮР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.РАДНААБАЗАР
ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс олгох санхүүжилтийн дүнг 49,712.7 мянган төгрөгөөр, дутуу санхүүжүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар цалин олголттой холбоотой 1,856.7 мянган төгрөгийн, төсвийн зарцуулалттай холбоотой 33,732.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж холбогдох шийдвэрийг гаргасан болно

### Бусад асуудлын хэсэг

Цагаан-Үүр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.0 хувьтай тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлан* */төгрөгөөр/*

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ |
|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **444,652,383.03** | **430,305,246.25** |
| **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **53,537,492.38** | **10,585,072.50** |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | 53,537,492.38 | 10,585,072.50 |
| Төгрөг | 53,537,492.38 | 10,585,072.50 |
| Төрийн сангийн харилцах | 53,537,492.38 | 10,585,072.50 |
| **АВЛАГА** | **15,892.00** | **15,892.00** |
| Ажиллагсадтай холбогдсон авлага | 15,892.00 | 15,892.00 |
| **БАРАА МАТЕРИАЛ** | **391,098,998.65** | **419,704,281.75** |
| Түүхий эд материал | 16,976,570.00 | 16,976,570.00 |
| Тусгай зориулалттай материал | 16,804,350.00 | 16,804,350.00 |
| Эм боох материал | 172,220.00 | 172,220.00 |
| **Хангамжийн материал** | **374,122,428.65** | **402,727,711.75** |
| Бичиг хэргийн материал | 4,649,230.00 | 5,193,230.00 |
| Аж ахуйн материал | 6,947,100.00 | 8,926,350.00 |
| Түлш шатах тослох материал | 34,970,265.51 | 6,737,000.25 |
| Барилгын засварын материал | 1,567,800.00 | 3,526,360.00 |
| Хүнсний материал | 55,580,173.11 | 44,943,790.52 |
| Бусад хангамжийн материал | 270,407,860.03 | 333,400,980.98 |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **858,742,124.93** | **816,708,026.04** |
| **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **858,742,124.93** | **816,708,026.04** |
| Биет хөрөнгө | 782,699,124.81 | 742,545,026.04 |
| Барилга, байгууламж | 351,395,213.33 | 351,395,213.33 |
| Хуримтлагдсан элэгдэл | (111,278,642.69) | (131,174,793.23) |
| Авто тээврийн хэрэгсэл | 79,800,000.00 | 79,800,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (4,433,333.32) | (17,733,333.28) |
| Машин, тоног төхөөрөмж | 551,651,814.20 | 611,403,174.20 |
| Хуримтлагдсан элэгдэл | (180,820,138.82) | (287,273,260.87) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 37,708,655.72 | 61,898,655.72 |
| Хуримтлагдсан элэгдэл | (17,307,844.21) | (19,443,380.43) |
| Бусад үндсэн хөрөнгө | 49,312,811.40 | 70,012,811.40 |
| Хуримтлагдсан элэгдэл | (38,068,106.22) | (42,166,665.66) |
| Дуусаагүй барилга, байгууламж | 41,797,894.00 | 41,797,894.00 |
| Номын фонд | 22,940,801.42 | 24,028,710.86 |
| Биет бус хөрөнгө | 76,043,000.12 | 74,163,000.00 |
| Програм хангамж | 5,737,000.00 | 5,737,000.00 |
| Хасагдуулга | (3,856,999.88) | (5,737,000.00) |
| Бусад биет бус хөрөнгө | 74,163,000.00 | 74,163,000.00 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,303,394,507.96** | **1,247,013,272.29** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **99,967,986.85** | **79,641,509.55** |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **61,011,032.85** | **40,684,555.55** |
| Богино хугацаат зээлийн өглөг | 52,945,746.00 | 3,541,446.00 |

| | | |
|---|---|---|
| Төгрөг | 52,945,746.00 | 3,541,446.00 |
| Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 52,945,746.00 | 3,541,446.00 |
| **Өглөг** | **8,065,286.85** | **37,143,109.55** |
| Ажиллагчидтай холбогдсон өглөг | (0.00) | 33,732,217.63 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 8,065,286.85 | 2,810,491.92 |
| Бусад өглөг | - | 600,400.00 |
| Байгууллагад төлөх өглөг | - | 600,400.00 |
| **УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР** | **38,956,954.00** | **38,956,954.00** |
| Урт хугацаат зээл | 38,956,954.00 | 38,956,954.00 |
| Төгрөг | 38,956,954.00 | 38,956,954.00 |
| Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 38,956,954.00 | 38,956,954.00 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **1,203,426,521.11** | **1,167,371,762.74** |
| Засгийн газрын хувь оролцоо | 1,203,426,521.11 | 1,167,371,762.74 |
| Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 450,514,427.06 | 450,514,427.06 |
| Өмч: -Төрийн өмч | 450,514,427.06 | 450,514,427.06 |
| Хуримтлагдсан үр дүн | 502,197,859.94 | 466,143,101.57 |
| Өмнөх үеийн үр дүн | 502,197,859.94 | 502,197,859.94 |
| Тайлант үеийн үр дүн | - | (36,054,758.37) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 250,714,234.11 | 250,714,234.11 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **1,303,394,507.96** | **1,247,013,272.29** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

***Хүснэгт 2.*** *Санхүүгийн үр дүнгийн тайлан* */төгрөгөөр/*

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,613,098,605.20** | **3,111,350,490.39** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **231,220,705.20** | **182,288,090.39** |
| **Нийтлэг татварын бус орлого** | **231,220,705.20** | **182,288,090.39** |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 231,220,705.20 | 10,704,700.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,880,500.00 | 8,529,700.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,175,000.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 229,340,205.20 | - |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө | - | 94,349,269.44 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал | - | 77,234,120.95 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,381,877,900.00** | **2,929,062,400.00** |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 2,246,877,900.00 | 2,780,062,400.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,246,877,900.00 | 2,780,062,400.00 |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **135,000,000.00** | **149,000,000.00** |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуллага/ | 135,000,000.00 | 149,000,000.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **2,501,644,263.59** | **3,127,699,248.76** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,501,644,263.59** | **3,127,699,248.76** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,440,308,677.59** | **2,959,207,824.30** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,708,874,270.01 | 2,144,534,760.96 |
| Цалин | 1,087,953,160.07 | 1,247,644,974.41 |
| Нэмэгдэл цалин | 566,531,816.40 | 749,415,986.55 |
| Унаа хоолны хөнгөлөлт | - | 66,185,000.00 |
| Урамшуулал | 54,389,293.54 | 81,288,800.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **210,463,411.46** | **268,937,440.67** |

| | | |
|---|---|---|
| Тэтгэврийн даатгалын шимтгэл | 143,673,272.00 | 187,129,516.80 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 17,142,994.38 | 20,577,445.53 |
| ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 8,561,597.94 | 10,433,203.12 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 8,247,724.05 | 10,159,475.39 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 32,837,823.09 | 40,637,799.83 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **142,768,153.90** | **162,860,805.07** |
| Гэрэл цахилгааны зардал | 37,780,003.90 | 44,614,705.07 |
| Түлш, халаалтын зардал | 104,988,150.00 | 118,246,100.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **23,898,415.50** | **39,621,195.26** |
| Бичиг хэргийн материал | - | 15,606,400.00 |
| Тээвэр, шатахууны зардал | - | 19,643,845.26 |
| Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | - | 4,370,950.00 |
| Бараа материал актасны зардал | 23,898,415.50 | - |
| Нормативт зардал | 104,737,266.00 | 146,768,492.13 |
| Хоол | 104,737,266.00 | 146,768,492.13 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,288,800.00** | **8,335,440.00** |
| Урсгал засвар | 7,288,800.00 | 8,335,440.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 19,281,454.05 | 27,201,221.88 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,740,500.00 | - |
| Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 17,540,954.05 | 27,201,221.88 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **222,996,906.67** | **160,948,468.33** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 82,878,300.00 | 13,185,100.00 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 14,769,200.00 | - |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 125,349,406.67 | 147,763,368.33 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,335,586.00** | **168,491,424.46** |
| Бусад урсгал шилжүүлэг | 61,335,586.00 | 168,491,424.46 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 61,335,586.00 | 143,103,690.46 |
| Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 25,387,734.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **111,454,341.61** | **(16,348,758.37)** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **2,069,444.37** | **19,706,000.00** |
| Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,069,444.37 | - |
| Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 19,706,000.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | **(2,069,444.37)** | **(19,706,000.00)** |
| **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **109,384,897.24** | **(36,054,758.37)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

***Хүснэгт 3**. Өмч өөрчлөлтийн тайлан* *төгрөгөөр*

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 450,514,427.06 | 445,126,384.63 | -123,193,681.01 | 772,447,130.68 |
| 2 | Тайлант үеийн үр дүн | | | 100,524,220.41 | 100,524,220.41 |
| 3 | 2024 оны 12-р сарын 31- | 450,514,427.06 | 250,714,234.11 | 502,197,859.94 | 1,203,426,521.11 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | нээрх үлдэгдэл | | | | |
| 4 | Тайлант үеийн үр дүн | | | -36,054,758.37 | -36,054,758.37 |
| 5 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 450,514,427.06 | 250,714,234.11 | 466,143,101.57 | 1,167,371,762.74 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

***Хүснэгт 4.*** *Мөнгөн гүйлгээний тайлан* *төгрөгөөр*

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,383,758,400.00** | **2,939,767,100.00** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,880,500.00** | **10,704,700.00** |
| **Нийтлэг татварын бус орлого** | **1,880,500.00** | **10,704,700.00** |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,880,500.00 | 10,704,700.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,880,500.00 | 8,529,700.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,175,000.00 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,381,877,900.00** | **2,929,062,400.00** |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 2,246,877,900.00 | 2,780,062,400.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,246,877,900.00 | 2,780,062,400.00 |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **135,000,000.00** | **149,000,000.00** |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 135,000,000.00 | 149,000,000.00 |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **2,357,015,661.88** | **2,971,339,519.88** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,357,015,661.88** | **2,971,339,519.88** |
| **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,288,049,261.88** | **2,842,072,685.88** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,706,236,121.63** | **2,115,225,084.00** |
| Үндсэн цалин | 1,044,911,681.98 | 1,141,064,141.59 |
| Нэмэгдэл | 606,888,714.40 | 826,781,599.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | - | 64,913,759.41 |
| Үр дүнгийн урамшуулал | 54,435,725.25 | 82,465,584.00 |
| **Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл** | **211,639,990.84** | **264,514,900.00** |
| Тэтгэврийн даатгалын шимтгэл | 143,884,690.84 | 179,869,800.00 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 16,948,900.00 | 21,161,300.00 |
| ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 8,474,400.00 | 10,580,800.00 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 8,474,400.00 | 10,580,800.00 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 33,857,600.00 | 42,322,200.00 |
| **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **125,000,000.00** | **139,000,000.00** |
| Гэрэл цахилгааны зардал | 36,000,000.00 | 45,002,000.00 |
| Түлш, халаалтын зардал | 85,000,000.00 | 89,998,000.00 |
| Цэвэр, бохир усны зардал | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| **Нормативт зардал** | **118,339,400.00** | **175,356,700.00** |
| Хоол, хүнс | 118,339,400.00 | 175,356,700.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **22,603,454.05** | **36,525,621.88** |

| | | |
|---|---|---|
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 1,740,500.00 | 7,760,900.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 20,862,954.05 | 28,764,721.88 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **94,230,295.36** | **101,450,380.00** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 79,430,600.36 | 90,707,780.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 14,799,695.00 | 10,742,600.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **68,966,400.00** | **129,266,834.00** |
| Бусад урсгал шилжүүлэг | 68,966,400.00 | 129,266,834.00 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 68,966,400.00 | 103,879,100.00 |
| Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 25,387,734.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **26,742,738.12** | **(31,572,419.88)** |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 73,052,000.00 | 11,380,000.00 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 73,052,000.00 | 11,380,000.00 |
| Дотоод эх үүсвэрээр | 73,052,000.00 | 11,380,000.00 |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 73,052,000.00 | 11,380,000.00 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(73,052,000.00)** | **(11,380,000.00)** |
| САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(46,309,261.88)** | **(42,952,419.88)** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 99,846,754.26 | 53,537,492.38 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 53,537,492.38 | 10,585,072.50 |

## 2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

***Хүснэгт 5**. төсвийн гүйцэтгэлийн тайлан* */Төгрөгөөр/*

| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Татаас, санхүүжилтийн орлого** | **3,034,606,500.00** | **2,939,767,100.00** | **94,839,400.00** | **96.87** |
| Улсын төсвөөс | 2,829,775,100.00 | 2,780,062,400.00 | 49,712,700.00 | 98.24 |
| Орон нутгийн төсвөөс | 149,000,000.00 | 149,000,000.00 | | 100.00 |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 7,760,900.00 | 8,529,700.00 | -768,800.00 | 109.91 |
| Туслах үйл ажиллагааны орлого | 2,175,000.00 | 2,175,000.00 | | 100.00 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 45,895,500.00 | | 45,895,500.00 | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,034,606,500.00** | **2,939,767,100.00** | **94,839,400.00** | **96.87** |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **3,034,606,500.00** | **2,982,719,519.88** | **51,886,980.12** | **98.29** |
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | | | | |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,154,703,800.00** | **2,115,225,084.00** | **39,478,716.00** | 98.17 |
| Цалин | 1,259,358,300.00 | 1,141,064,141.59 | 118,294,158.41 | 90.61 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 895,345,500.00 | 974,160,942.41 | (78,815,442.41) | 111.2 |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **269,338,200.00** | **264,514,900.00** | **4,823,300.00** | **98.21** |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 226,244,100.00 | 222,192,700.00 | 4,051,400.00 | 98.21 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 43,094,100.00 | 42,322,200.00 | 771,900.00 | 98.21 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бараа ,үйлчилгээний урсгал зардал** | **504,597,400.00** | **443,709,583.80** | **60,887,816.20** | **87.93** |
| Тогтмол зардал | **139,000,000.00** | **139,000,000.00** | **0.00** | **99.90** |
| Гэрэл цахилгааны зардал | 45,000,000.00 | 45,002,000.00 | -2,000.00 | 100.00 |
| Түлш, халаалтын зардал | 90,000,000.00 | 89,998,000.00 | 2,000.00 | 100.00 |
| Цэвэр, бохир усны зардал | 4,000,000.00 | 4,000,000.00 | | 100.00 |
| **Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал** | **471,564,500.00** | **463,979,535.88** | **7,584,964.12** | **98.4** |
| Хоол | 175,356,700.00 | 175,356,700.00 | - | 100.00 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 102,514,800.00 | 102,087,780.00 | 427,020.00 | 99.58 |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 10,742,600.00 | 10,742,600.00 | - | 100.00 |
| Урсгал засварын зардал | 10,000,000.00 | 10,000,000.00 | 0 | 100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,760,900.00 | 7,760,900.00 | - | 100.00 |
| Мэдээллийн технологийн зардал | 29,292,000.00 | 28,764,721.88 | 527,278.12 | 98.20 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 110,179,100.00 | 103,879,100.00 | 6,300,000.00 | 94.28 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 25,718,400.00 | 25,387,734.00 | 330,666.00 | 98.71 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 53,537,492.38 | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 10,585,072.50 | | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 193,341.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 193,341.7 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайланд 193,341.7 мянган төгрөгийн орлого, зардлыг алдаатай тайлагнасныг нягтлан бодогч хүлээн зөвшөөрч залруулга хийсэн

Аудитаар нийт 607,014.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,856.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 605,157.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

### 3.1 Төлбөрийн акт

1. Нэр бүхий 12 багшид илүү цагийн мөнгийг 643.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон, нэр бүхий 3 ажилтанд 1,212.8 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгосон байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, гэж заасныг тус тус зөрчсөн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал,хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 тушаалын хавсралтаар батлагдсан “Цэцэрлэг,ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох,багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 2.11-д Сургуулийн багш долоо хоногт 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил,6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ .Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цаг нь хичээл заах цагт зориулагдана” гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### 3.2 Албан шаардлага

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Албан шаардлага хүргүүлээгүй.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

1. Ээлжийн ажилтнуудыг уртын ээлжээр 12 цаг ажиллуулан шөнийн цагийн нэмэгдэлд 43,558.0 төгрөг олгосноос шалтгаалан оны эцэст ажиллагсадтай холбоотой 33,732.2 мянган төгрөгийн өр үүссэн байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 92.1-д “Ажилтныг байнга оршин суугаа газраас нь өөр, алслагдсан газар байрлуулж ажил үүрэг гүйцэтгүүлэхээр уул уурхай, олборлох салбарын ажил олгогч уртын ээлжээр ажиллуулах горим хэрэглэж болно.”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

1. Ээлжийн ажлын цагийн үргэлжлэх хугацааг Хөдөлмөрийн тухай хуулийн 87.2-д заасны дагуу тогтоож, шөнийн цагаар ажилласан ажилтныг дараагийн ажлын өдөр нь шөнө ажилласан цагаас багагүй хугацаагаар нөхөн амраах байдлаар зохицуулалт хийн, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

**Нийцлийн асуудалтай холбоотой**

*Илрүүлэлт:*

1. 2025 оны 1 сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй, ажилтныг буцаан томилохдоо гэрээ байгуулаагүй нь Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д “Мэдээлэл хариуцагч ажлын байрны сул орон тооны талаарх Мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.” гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

*Өгсөн зөвлөмж*:

1. Байгууллагад гарсан ажлын байрны сул орон тооны мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд зарлах, ажлаас чөлөөгдсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээ байгуулан, цалин хөлсийг олгох;

*Илрүүлэлт:*

2. Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 356,710.5 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 165,690.9 мянган төгрөгөөр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээг 49,024.1 мянган төгрөгөөөр тус тус дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,1,6.1.6, 6.4.4, 6.4.5--д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

*Өгсөн зөвлөмж*:

2. Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Хүснэгт 7.** *Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд 193,341.7 мянган төгрөгийн орлого, зардлыг алдаатай тайлагнасан | 1 | 193,341.7 | | | 1 | 193,341.7 | 1 | 193,341.7 | | | | |
| **Дүн** | **1** | **193,341.7** | | | **1** | **193,341.7** | **1** | **193,341.7** | | | | |

**Хүснэгт 8.** *Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нэр бүхий ажилтнуудад илүү цагийн мөнгө, ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгосон байна | 1 | 1,856.7 | 1 | 1,856.7 | | | | |
| Тайлант оны эцэст ажиллагсадтай холбоотой 33,732.2 мянган төгрөгийн өр үүссэн байна | 1 | 33,732.2 | | | 1 | 33,732.2 | | |
| **Дүн** | **2** | **35,588.9** | 1 | 1,856.7 | **1** | **33,732.2** | | |

**Хүснэгт 9.** *Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал*

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илэрсэн. | | | | | | | | |
| 2025 оны 1 сард гарсан 1 сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй, ажилтныг буцаан томилохдоо гэрээ байгуулаагүй | 1 | | | | | | 1 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн дансны мэдээлэл дутуу мэдээлсэн | 1 | 571,425.5 | | | | | 1 | 571,425.5 |
| **Дүн** | **2** | 571,425.5 | | | | | **2** | 571,425.5 |